



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ  
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 26 өдөр

Дугаар А/192

Бат-Өлзий сум

Туузан гэрэл, цамхагт гэрэлтүүлгийн  
ажлын гүйцэтгэлийг хүлээн авах  
ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.6 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.3.8, 9.12, 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Засаг даргын Тамгын газарт туузан гэрэл, Цех, Үржүүлгийн хооронд цамхагт гэрэлтүүлэг хийж гүйцэтгэсэн ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч: Н.Бат-Эрдэнэ (Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд: С.Төмөр (3 дугаар багийн Засаг дарга)

Г.Бямбагарав (5 дугаар багийн Засаг дарга)

Д.Мөнх (Цахилгаан шугам сүлжээний салбарын эрхлэгч)

Г.Бүд (Засаг даргын Тамгын газрын нярав)

2. Захиалагчийн техникийн тодорхойлолт, шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдлыг хянан үзэж, гэрээний шаардлагыг биелүүлсэн нөхцөлд акт үйлдэн хүлээн авахыг ажлын хэсэг (Н.Бат-Эрдэнэ), хөрөнгийг байгууллагын өмчийн бүртгэлд бүртгэхийг Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч (Ч.Батдулам) нарт тус тус үүрэг болгосугай.

3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр бий болсон туузан гэрэл болон цамхагт гэрэлтүүлгийн ашиглалт, хамгаалалтанд байнгын хяналт тавьж ажиллахыг өмч хамгаалах байнгын зөвлөлийн дарга (Э.Дашдулам)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН